Сангийн сайдын 2023 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн А/258 дугаар
тушаалын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

# БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

2024 он

**УВС УЛААНГОМ СУМЫН**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 4-Р СУРГУУЛ**

# БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

| | |
|---|---|
| Тендер шалгаруулалтын нэр: | **Хүүхдийн үдийн хоолны материал нийлүүлэх** |
| Тендер шалгаруулалтын дугаар: | **УВААС4/202400101** |

4007689 1522120017

ЗАХИРАЛ Г.БАДАМХАТАН

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

| | |
|---|---|
| **1. Тендерийн цар хүрээ** | 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "**Хууль**" гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид "**бараа**" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ. |
| | 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана. |
| **2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг** | 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана. |
| **3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж** | 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. |
| **4. Худалдан авах ажиллагааны цахим систем** | 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна. |
| **5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх** | 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |
| | 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, $20^1$, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| **6.** | **Сонирхогч этгээд, оролцогч** | 6.1. | Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ. |
| | | 6.2. | Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна. |
| | | 6.3. | Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй. |
| | | 6.4. | Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна. |
| | | 6.5. | ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй. |
| **7.** | **Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ** | 7.1. | Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. |
| | | 7.2. | Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй. |
| | | 7.3. | Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна. |
| | | 7.4. | ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй. |
| | | 7.5. | Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ. |
| **8.** | **Нийлүүлэх барааны гарал үүсэл** | 8.1. | ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. |
| | | | **Б.АГУУЛГА** |
| **9.** | **Тендер шалгаруулалтын баримт бичиг** | 9.1. | Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:<br>I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;<br>II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;<br>III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;<br>IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;<br>V Бүлэг. Тендерийн жишиг маягт;<br>VI Бүлэг. Гэрээний нөхцөл. |
| | | 9.2. | Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална. |
| | | 9.3. | Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, |

тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, заавбрыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

| | | |
|---|---|---|
| **10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах** | 10.1. | Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ. |
| | 10.2. | ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана. |
| | 10.3. | Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ. |
| **11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт** | 11.1. | Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна. |
| | 11.2. | ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. |

## В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

| | | |
|---|---|---|
| **12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл** | 12.1. | Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ. |
| | 12.2. | Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно. |
| | 12.3. | Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална. |
| | 12.4. | Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна. |
| **13. Тендерийн иж бүрдэл** | 13.1. | Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна. |

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;

13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;

13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

**14. Тендерийн жишиг маягтууд**

14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.

**15. Хувилбарт санал**

15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.

**16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг**

16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.

16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.

16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас

гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

**17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**

17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн **Error! Reference source not ound.**-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.

17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.

17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.

17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.

17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.

17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.

17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт,

барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;

17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;

17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.

17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

**18. Чадавхын болон туршлагын шаардлага**

18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

**19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.

19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

**20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**

20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

**21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.

21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.

21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.

21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр

хэрэглэнэ.

21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

**22. Тендерийн валют**

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

**23. Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

**24. Тендерийн баталгаа**

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

| | | |
|---|---|---|
| **25. Тендер баталгаажуулах, илгээх** | 25.1. | Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ. |
| | 25.2. | ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй. |
| | 25.3. | Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй. |
| | 25.4. | Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн **Error! Reference source not found.**-ын дагуу ууцлахгүйгээр ирүүлнэ. |
| | 25.5. | Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ. |
| **26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа** | 26.1. | Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно. |
| | 26.2. | Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй. |

## Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

| | | |
|---|---|---|
| **27. Тендерийн талаар тодруулга авах** | 27.1. | Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална. |
| **28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх** | 28.1. | Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ. |
| **29. Тендерийг үнэлэх** | 29.1. | Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна. |
| | 29.2. | Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна. |
| **30. Арифметик алдааг залруулах** | 30.1. | Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна. |

| | | |
|---|---|---|
| | 30.2. | ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ. |
| **31. Давуу эрх олгох** | 31.1. | Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно. |
| | 31.2. | ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй. |
| | 31.3. | Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай. |
| **32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт** | 32.1. | Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ. |
| **33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох** | 33.1. | Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална. |
| | 33.2. | ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. |
| | 33.3. | ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална. |
| **34. Тендерийг эрэмбэлэх** | 34.1. | Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална. |
| **35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах** | 35.1. | Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална. |
| | 35.2. | ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ. |
| | 35.3. | ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно. |

## Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

| | | |
|---|---|---|
| **36. Шийдвэр хүргүүлэх** | 36.1. | Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ. |
| **37. Гүйцэтгэлийн баталгаа** | 37.1. | Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн |

баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

# II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

| **ТШЗ-ны холбогдох заалт** | **А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ** |
|---|---|
| **ТШЗ 1.1** | Захиалагч: ***Улаангом сумын ЕБ-ын 4-р сургууль*** |
| **ТШЗ 1.1** | Тендер шалгаруулалтын нэр: ***Хүүхдийн үдийн хоол үйлдвэрлэл*** |
| **ТШЗ 1.1** | Тендерийн урилгын дугаар: **УВААС4/202400101** |
| **ТШЗ 1.2** | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:<br>***1 –р áàãö:  Гурилан бүтээгдэхүүн***<br>***2 –р áàãö:  Хүнсний ногоо***<br>***3 - р багц:  Сүү, сүүн бүтээгдэхүүн***<br>***4-р  багц:  Мах /үхэр, хонь /***<br>***5-р  багц:  Хүнсний КГ-ын бүтээгдэхүүн,жимс жимсгэнэ***<br>***6 –р багц:Жимсний шүүс/үхрийн нүд, чацаргана жимсээрээ ань*** |
| **ТШЗ 1.3** | Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич:<br>***Хоол үйлдвэрлэл***<br>***Хамрагдах сургуулийн хүүхдийн тоо 496*** |
| **ТШЗ 1.4** | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***[ "Үгүй"].*** |
| **ТШЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: ***Улсын төсөв*** |
| **ТШЗ 2.1** | Нийт төсөвт өртөг: ***113.189.400 төгрөг***<br>***Багц №: Мах махан бүтээгдэхүүн 36.220.608 төгрөг***<br>***Багц №: Гурил гурилан бүтээгдэхүүн 14.714.622 төгрөг***<br>***Багц №: Хүнсний ногоо 12.450.834 төгрөг***<br>***Багц №: Сүү сүүн бүтээгдэхүүн 16.978.410 төгрөг***<br>***Багц №: КГ-ын бүтээгдэхүүн 24.901.668 төгрөг***<br>***Багц №: Жимс жимсгэнэ, шүүс 7.923.258 төгрөг*** |
| **Б. АГУУЛГА** | |
| **ТШЗ 8.1** | Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:<br>Хүлээн авагчийн нэр: ***Нярав Г.Алтанхуяг***<br>Хаяг: ***ЕБ-ын 4-р сургууль***<br>Утасны дугаар:  ***70452894, 70459009, 86653366, 95731517*** |

| | |
|---|---|
| | Цахим шуудангийн хаяг: |
| **ТШЗ 11.1** | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: ***“Үгүй”*** |
| **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ** | |
| **ТШЗ 12.2** | Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: ***“Монгол хэл”*** |
| **ТШЗ 15.1** | Хувилбарт санал ирүүлэхийг: ***“Зөвшөөрөхгүй”*** |
| **ТШЗ 17.4** | Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: ***“Үгүй”*** |
| **ТШЗ 17.6** | Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: ***“Үгүй”*** |
| **ТШЗ 18.2** | Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: ***“Шаардана”***<br><br>**Тухайн бүтээгдэхүүн нийлүүлэх компани болон аж ахуйн нэгж Улсын бүртгэлийн гэрчилгээн дээр тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон нийлүүлэх борлуулах эрхтэй байх** |
| **ТШЗ 18.2.5** | Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: ***“Шаардана”***<br>*1. Сүүлийн 3жилд / 2020 он/ гэрээгээр гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлэлтийн ажлын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, нотлох баримтууд /нотариатаар баталгаажуулж ирүүлэх/*<br>*2. Гэрээний үүргээ биелүүлсэн талаар өмнөх захиалагчийн үнэлгээ, тодорхойлолтыг заавал ирүүлэх.*<br>*3. Голлох мэргэжилтэн, ажилтны танилцуулга, мэргэжлийн үнэмлэх, дипломны хуулбар*<br>*4. Барааны техникийн тодорхойлолт, үзүүлэлтийг гаргаж эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж ирүүлэх,*<br>*5. Нийлүүлэх барааны стандартыг гаргаж байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж ирүүлэх. /Монгол улсад мөрдөж буй стандартад нийцсэн байх./*<br>*6. Барааны чанарын баталгааны гэрчилгээний хуулбар /нотариатаар Батлуулж ирүүлэх/*<br>*7. Тендерийн баримт бичгийн 6, 7-р бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрсөн тухай албан бичгээр мэдэгдэл гаргаж ирүүлнэ.*<br>*8. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа, тодорхойлолтыг тендерт авчирүүлэх, /эх хувиар/*<br>*9. Харъяа татвар, Нийгмийн даатгалын хэлтэс, Шүүх, ШШГБ-уудын тодорхойлолт ирүүлнэ /тодорхойлолтууд 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх, хуулбар хувь ирүүлэх бол хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлж болно/.*<br>*10. Нийлүүлэх барааны баталгаат хугацааны мэдэгдэл гаргаж ирүүлэх.*<br>*11. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /**Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана**./*<br>*12. Тендерт оролцогч уг тендерийн багцад шалгарсан тохиолдолд санал болгосон үнэд багтаан барааг нийлүүлж гэрээний үүргээ биелүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.*<br>*13. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулж ирүүлнэ/*<br>*14. Ажлын байрны дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргаж ирүүлэх.(2020 онд)*<br>*15. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийн хуулбар*<br>*16. Хүнсний бүтээгдэхүүн агуулах байрны /зоорь/ гэрчилгээний хуулбар, түрээсийнх бол 2022 оны түрээсийн гэрээний хуулбар, зураг ирүүлэх,*<br>*17. Мэргэжлийн хяналтын газраас сүүлийн 1 жилд / 2022он/ тавьсан акт, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай нотлох баримтыг ирүүлэх /мэргэжлийн хяналтын* |

| | |
|---|---|
| | *газраас акт, дүгнэлт, албан шаардлага авсан тендерт оролцогчид хамаарна/*<br>*18. Тендерт оролцогчийн захирал, дарга, нягтлан бодогч, борлуулалтын менежер гэх мэт удирдах албан тушаалтны иргэний үнэмлэхний хуулбарыг ирүүлэх.*<br>*19. Тендерт оролцогч үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх тухай, үнийн өсөлтөөс хамаарах эрсдлийг өөрөө хариуцах тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлэх,*<br>*20. Үйлдвэрийн хүчин чадал*<br>*21.Улсын болон аймгийн мал эмнэлэгийн лабраторт махаа шинжлүүлсэн тухай шинжилгээний дүгнэлт*<br>*22.****Стандарт хэмжил зүйн хэлтсийн баталгаажуулал танд хамрагдаж тохирлын гэрчилгээ авсан байх / хугацаа дуусаагүй /***<br><br>23. Ажилтны хүнс үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжил эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг<br>24. Тендерт оролцогчийн багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт<br>25.Хүнсний үйлдвэрлэл явуулах зөвшөөрөл,<br>26. Орчны ариун цэврийн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулах.<br>27.Үдийн хоолонд нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүнийг долоо хоногын хоолны цэст хуваан 4 долоо хоногийн цэс зохиож ирнэ.<br>28. Бүтээгдэхүүний жагсаалт<br>29. Жагсаалтанд орсон бүтээгдэхүүн тус бүрийн орц, норм<br>30. Тухайн бүтээгдэхүүний өртөг Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: *[Тендэрт оролцогчийн санал болгож буй бүх бүтээгдэхүүнийг хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжтэй байна. ]*<br>Амталгааны зориулалтаар 4 долоо хоногийн цэсэнд орсон бүтээгдэхүүнийг нэг хүүхдэд ногдох нормоор савлан амтлуулна.<br>31.Тухайн бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэлийн бичиг баримт, фото зураг<br>32. Ажилчдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлсон мэргэжлийн байгууллагын үзлэг, шинжилгээний бичиг ирүүлэх.<br>33. Хүнсний технологийн карт, цэс, орц, норм, путёвк<br>*34.* Дээрх материалуудыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно |
| **ТШЗ 19.1** | Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: ***“Тийм”***<br><br>***Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16.2, 16.4-т заасан хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн [тоо бичих] хувиас багагүй байх.***<br><br>***Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланг аудитын байгуулагаар баталгаажуулсан байх*** |
| **ТШЗ 20.1** | Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх:<br><br>***Ижил төстэй бараа ажил үйлчилгээ явуулж байсан гэрээний хуулбар оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох нийлүүлэгч, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ, эсхүл тэдгээрээс энэ тухай гаргасан албан бичиг;***<br><br>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: ***“Шаардана”***<br><br>***Хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх*** |
| **ТШЗ 21.5.** | Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад:<br><br>***Гэрээний үнийн дүн өөрчлөгдөхгүй*** |

| | |
|---|---|
| **ТШЗ 21.6** | Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: ***“Үгүй”*** |
| **ТШЗ 24.1** | Тендерийн баталгааны дүн: **50.000 төгрөг** |
| **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ** | |
| **ТШЗ 25.5.** | Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:<br>***1. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл;***<br>***2. Санал болгосон бараг нийлүүлэх боломжтой болохыг нотлох баримт гэх мэт баримт бичгийг жагсаан бичих*** |
| **ТШЗ 26.1.** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Огноо: ***2024 оны 02 дүгээр сарын 12-ны өдөр***<br>Цаг: ***13 цаг 00 минут*** |
| **ТШЗ 26.2.** | Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.<br>Огноо: ***2024 оны 02 дүгээр сарын 12-ны өдөр***<br>Цаг: ***13 цаг 30 минут***<br>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: ***Увс аймаг Улаангом сум ЕБ-ын 4-р сургууль*** |
| **ТШЗ 28.2** | Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх:<br>**1. Байгууллагын товч танилцуулга, ажлын туршлага**<br>**2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар үйл ажиллагаа эрхлэх чиглэл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан борлуулах зөвшөөрөл**<br>**3. Бараа хүргэх тээврийн хэрэгсэлтэй эсэх тээврийн хэрэгслэлийн гэрчилгээний хуулбар, зургийг нь өнгөтөөр хэвлэж хавсаргах**<br>**4. Хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтын сав агуулахын зураг байршил, гэрчилгээний хуулбар, түрээснийх бол 2022- 2023 оны түрээсийн гэрээний хуулбар**<br>**5. Нийлүүлэх бүтээгдэхүүн тус бүрд Мэргэжлийн байгууллагын лабораторийн шинжилгээний бичиг, дүгнэлтийн хамт**<br>**6. Нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт ,бүтээгдэхүүн тус бүрийн орц, норм, нийлүүлэх үнэ**<br>**7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /эх хувь/ тендер зарласнаас тендер хүлээн авах хүртэлх хугацаагаар авсан байна.**<br>**8. Тендерт оролцогч гэрээний хугацанд зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарах эрсдлийг өөрөө хариуцаж тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлэх**<br>**9. Тоног төхөөрөмж болон бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажиллах хүчин чадлын мэдээлэл**<br>**10. Үйлдвэрлэгч ажилтнуудын шинжилгээнд орсон эрүүл ахуй, ариун цэврийн бичиг / цагаан дэвтэр -6 сар дутам /**<br>**Санхүүгийн баталгаажсан тайлан -2023 он хагас жил** |

Боловсрол соёл, шинжлэх ухааны яамны
сайдын 2006 оны 08 сарын 23-ны
301 дугаар тоот тушаал

# ҮДИЙН ХООЛ ХӨТӨЛБӨР

Сургалтын менежерээс гүйцэтгэх үүрэг

- Талуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээг дүгнэж захиралд танилцуулах
- Үдийн хоолны цэс зохиох ба үдийн хоолны эрүүл ахуйд хяналт тавих
- Шим тэжээлийн бодис ба зөв хооллох дэглэмийн талаар сурагчдад сургалт явуулах, эцэг эхэд зөвөлгөө өгөх
- Үдийн хоолны өмнө анги танхимын ариун цэвэр, сурагч бүрийн гарыг угаалгаж буй эсэхэд хяналт тавих, үдийн хоол бэлтгэж буй ажилчдын хүнсний аюулгүй ажиллагааны горим мөрдөж буй эсэхэд хяналт тавих, гарсан зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж ажиллах.

**Хориглох зүйл:** Давс болон хийжүүлсэн ундаа, хүнсний нэмэлтүүдийг аль болох хэрэглэхгүй байх
**Хүүхэд олгох хүнсний бүтээгдэхүүн нь :** Хоол хүнснээс гадна боов боорцог, печень, хачиртай талх зэрэг гурилан бүтээгдэхүүн, ундааны зүйлд сүүн бүтээгдэхүүн, ундаа, жимсний зүйл халуун цай зэрэг
**Нэг.** Үдийн хоолыг сургууль дээр зориулалтын газарт үйлдвэрлэх

1. Үдийн хоолны бүтээгдэхүүнийг гэрээт борлуулагчаар дамжуулах, хувь хүнээс худалдан авахыг хориглоно.
2. Үдийн хоолны цэсийг долоо хоног бүрээр сургуулийн эмч боловсруулж захирал батлана.
3. Хичээлийн хоёр буюу гуравдугаар цагийн завсарлагаанаар үдийн хоолыг ангид нь өгнө.
4. Үдийн хоолны үргэлжлэх хугацаа 15-аас 20 минут байна.
5. Үдийн хоолыг идэхээс өмнө хүүхэд бүрийн гарыг угаалгасан байна.
6. Сургуулийн эмч ба анги удирдсан багш улирал бүр суралцагсадын жин өндөрийг хэмжиж үнэлгээ дүгнэлт өгнө.
7. Сургууль, эмнэлгийн захиргаа, сургуулийн эцэг эхийн хорооны төлөөлөл бүхий хянлтын комисс байгуулж үдийн хоолны чанар зохион байгуулалтад байнгын хаяналт тавина.
8. Хяналтыг комиссын бага ангийн эцэг эхийн зөвлөлийн дарга ахлана.
9. Үдийн хоолонд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүнээс өдөр бүр дээж авч хадгалан бүртгэл хөтлөнө.

**Хоёр.** Үдийн хоолонд олгох хүнсний бүтээгдэхүүнд тавих шаардлага

1. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байх, гэрээт гүйцэтгэгчээс нийлүүлж байгаа нөхцөлд сав, баглаа, боодолтой, шошготой байх.
2. Амин дэм эрдэс бодисоор баяжуулсан бүтээгдэхүүн байх
3. Бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан байх

**Гурав.** Үдийн хоолны цэс зохиоход тавигдах шаардлага

4. Сурагчдын эрүүл мэнд, дур сонирхолд нийцсэн байх
5. Цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицлыг зөв сонгосон байх
6. Нэг сурагчийн үдийн хоол, өдрийн 1500 төгрөгт багтсан байх
7. Амархан муудаж чанараа алддаг хүнсний бүтээгдэхүүнийг цэсэд оруулахгүй байх
8. Сүү цагаан идээ, жимс, жимсгэний шүүс, баяжуулсан гурилаар хийсэн хүнсийг оруулсан байх
9. Цэсэд байгаа хүнсний бүтээгдэхүүний сард ноогдох давтамжийг хоёроос гурав байхаар тооцох
10. Печень, бялуу, шоклад, чихэр зэрэг бүтээгдэхүүн хийж үүслэн ундааг цэсэд оруулахгүй байх
11. Хүйтний улиралд халуун ундааны зүйлээр үйлчлэх /буцалгасан аарц, чацаргана, үхрийн нүд, аньсний шүүс, үзэмний шүүс / зэрэг бүтээгдэхүүн
12. Эклогийн цэвэр бүтээгдэхүүн болон аминдэм, эрдэс бодисоор баялаг бүтээгдэхүүнийг сонгох

**Дөрөв.** Гэрээт гүйцэтгэгчийн баримтлах шалгуурууд

1. Хүнсний үйдвэрлэл явуулах зөвшөөрөлтэй, улсын мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй байх
2. Сургуульд нийлүүлэхээр санал болгосон бүтээгдэхүүнийг эрүүл , аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамруулсан байх

3.Мах манан бүтээгдэхүүн дээр гарал үүслийн гэрчилгээтэй байх бэлтгэн нийлүүлэгчийн гэрээний хуулбар хавсаргах

4. Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу савлах, зөөж тээвэрлэх боломжтой байх
5. Хүнсний шинэ бүтээгдэхүүнээр үйлчлэх, хадгалалтын хэмийг баримтлах нөхцлийг бүрдүүлсэн байх

5. Бүтээгдэхүүнээ цайны цагаас 30-н минутын өмнө сургуулийн сурагчдад тараахад бэлэн байх

6. Гэрээний хэрэгжилтээс санхүүгийн хариуцлага хүлээх чадвартай байх
**7. ЭМС-ын 2013 оны 207 дугаар тушаалд орсон хүнсний бүтээгдэхүүн**
**Тав**. Үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих тайлагнах
1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн эрүүл мэндийн болон БСГазар, МХ-ын байгууллага хамтран хяналт тавина.

2. Сургуулийн үдийн хоолны үйлчилгээнд сургуулийн эмч өдөр тутмын хяналт тавьж ажиллана.
**Зургаа.** Сургуулийн эмчийн хийж гүйцэтгэх ажлууд
1. Талуудын гэрээний хэрэгжилтэд байнгийн хяналт тавих гэрээг дүгнэж захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулах

2. Шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүнийг буцаах

3. Анги удирдсан багшаар дамжуулан шим тэжээлийн бодис ба зөв хооллох дэглэмийн талаар сурагчдад сургалт явуулах, эцэг эхэд зөвлөгөө өгөх

4. Үдийн хоолны өмнө анги танхимын ариун цэвэр, сурагч бүрийн гарыг угаалгаж байгаа эсэхэд хяналт тавих

5. Таргалалттай болон жин багадалттай хүүхдэд онцгойлон анхаарал тавих ажлыг өрхийн эмчтэй хамтран зохион байгуулах

6. Үдийн хоол хөтөлбөрт ажиллагсад эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан эсэх, хүнсний аюулгүй ажиллагааны горим мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих гарсан зөрчил дутагдлыг тухай бүр нь арилгуулах
**Долоо.** Хяналтын комисс
1. Үдийн цайны үйлчилгээнд сургуулийн бага ангийн эцэг эхийн зөвлөлийн даргаар ахлуулсан хяналтын комисс хяналт тавина.

2. Хяналтын комиссоос хэлэлцэж баталсан хуваарийн дагуу үдийн хоолны үйлчилгээний чанарт хяналт тавих чиглэлүүд
2.1 Олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн нь эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх

2.2 Анги танхимын аруин цэвэр сурагчдын гарыг угаалгаж байгаа эсэх

2.3 Хүүхдийн дур сонирхол, эрүүл мэндэд тохирч байгаа эсэх

2.4 Цагтаа олгож байгаа эсэх

2.5 Дээж бүтээгдэхүүн авч байгаа эсэх

2.6 Үдийн хоолонд хяналт тавьсан хяналтын комиссын гишүүд үр дүнг сургуулийн захиралд тухай бүрд нь танилцуулна.
3. Үдийн хоолны үйлчилгээний талаар сургуулийн захиргаа улиралд нэг удаа эцэг эхэд танилцуулж санал бодлыг тусгана.
4. Сургуулийн захирал аймгийн боловсрол соёлын газраас үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг улирал бүрийн эцэст гаргаж БСУЯ-нд танилцуулна.

5. Үдийн хоолны үйлчилгээг шаардлагын хэмжээнд зохион байгуулаагүй хүүхдийн эрх ашгийг хохироосон нь шалгалтаар нотлогдсон байгууллага, албан тушаалтныг Боловсролын тухай хууль, бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : **_2024.01.15_**

Тендер шалгаруулалтын нэр: **_Хүүдийн үдийн хоолны бүтээгдэхүүн нийлүүлэх_**

Тендер шалгаруулалтын дугаар: **УВААС4/202400101**

**Увс аймаг Улаангом сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль нь эрх бүхий тендерт оролцогчдоос сургуулийн** нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг ***Хүүхдийн үдийн хоол үйлдвэрлэл*** гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:

. ***1 –р áàãö: Гурилан бүтээгдэхүүн***
***2 –р áàãö: Хүнсний ногоо***
***3 - р багц: Сүү, сүүн бүтээгдэхүүн***
***4-р багц: Мах /үхэр, хонь /***
***5-р багц: Хүнсний КГ-ын бүтээгдэхүүн,жимс жимсгэнэ***
***6 –р багц:Жимсний шүүс/үхрийн нүд, чацарганы шүүс аньс***

Тендерийг 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 13 цаг 00 минутаас өмнө цахимаар www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээллийг болон тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй ***50000*** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Гадаадын этгээд тендер ирүүлэх: Эрхгүй.
Дотоодийн давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй.

Оролцох хүсэлтэй компаниудыг урьж байна. Үнийн саналыг 2024 оны 02 дүгээр сарын 12-ны өдрийн 13 цаг 30 минутад нээнэ.

**Хаяг: Увс Улаангом сум 4-р баг Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн захиргаа**

**Утас:70452894, 70459009, 86653366, 99012441, 95731517**

ЗАХИРАЛ Г.БАДАМХАТАН

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр:

| **№** | ***Захиалагчийн техникийн тодорхойлолт*** (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.) | ***Санал болгож буй техникийн тодорхойлолт*** (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичих) | ***Тайлбар*** (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана) |
|---|---|---|---|
| 1 | | | |
| 2 | | | |
| 3 | | | |
| ... | | | |

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/- д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан тендерийн баримт бичгийг боловсруулна.]

Хавсралт

| ***Нэр төрлийн дугаар*** | ***Бараа болон холбогдох үйлчилгээний нэр*** | ***Техникийн тодорхойлолт болон стандарт*** тавигдах шаардлага |
|---|---|---|
| **Багц-1 Гурилан бүтээгдэхүүн** | Талх, Төрөл бүрийн нарийн боов | 4.1 Бүтээгдэхүүний чанар, хэлбэр, өнгө гадаргуу, амт үнэр зэрэг стандартын шаардлага хангасан үйлдвэрт баталгаажсан жор технологийн зааврыг баримтлан үйлдвэрлэсэн Хүүхдийн сонирхол татахуйц олон төрлийнбайна. /Амталгаа ирүүлнэ/ хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын уутанд савлаж, дараах мэдээлэлийгагуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд: •<br>4.2 Үйлдвэрлэгчийн нэр<br>• Бүтээгдэхүүний нэр, төрөл<br>• Цэвэр жин<br>• Үйлдвэрлэсэн огноо,<br>• Стандартын дугаар<br>• Хэрэглэх аргын заавар<br>Шошголохтой холбогдсон журам MNS6648:20162-ыншаардлага хангасан |
| | *Төмс* | 1.Нийлүүлэх төмс нь орон нутагт тариалагдсан, MNS 258:2006 стандартын шаардлага хангасан байна.<br>2 Мэргэжлийн хяналтын лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан<br>3. Шинэ буюу шинэлэг байдлаа хадгалсан байх<br>4. Хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, бүтэн,хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байх<br>5. Хальс нь шалбарсан төмс 10 хувиас ихгүй, ногоорсон төмсгүй,пестицидийн үлдэгдэлгүй байх<br>6. Гадны ямар нэг үнэртэй, химийн бодисоорбохирлогдсон байж болохгүй.<br>7. Төмсний голч хэмжээ 35-55 мм, 55мм-ээс дээш байна.<br>8 Төмсийг норох, хөлдөхөөс хамгаалж бүтээлэгтэй тээврийнхэрэгслээр тээвэрлэнэ.<br>9 Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээгхангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.<br>10. Намрын улиралд шинэ ургацын төмс нийлүүлэх. |

| | | |
|---|---|---|
| **Багц -2 Хүнсний ногоо** | Байцаа | 1. Нийлүүлэх байцаа нь орон нутагт тариалагдсан, MNS0255:2007стандартын шаардлага хангасан монгол байцаа байх<br>2. Мэргэжлийн хяналтын лабораторит улирлаар шинжлүүлсэнхүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан байх.<br>3. Байцаа нь нягтрал сайтай, бүтэн, цэвэр, өвчлөөгүй, хортон,хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, механик элдэв хольцгүй, гадны үнэр амтгүй,сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсанбайна.<br>4. Хадгалсан байцааг нийлүүлэхдээ гадна талын муудсан навчийгавч цэвэрлэсэн байх ба хөлдөлт, хайргадалтгүй байна. |
| | Сонгино Сармис | 1..Нийлүүлэх сонгино нь MNS 0260:1982 стандартын шаардлага хангасан, монгол, орос сонгино байна.<br>2 Мэргэжлийн хяналтын лабораторит улирлаар шинжлүүлсэн хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан,<br>3. Сонгино нь механик элдэв хольцгүй, хортон, хөнөөлт шавьжаар гэмтэж, бохирлогдоогүй, эрүүл, цэвэр, хуурай, сортынхоо хэлбэр, дүрсийг хадгалсан байна.<br>4. Булцуу нь нягт, ургаж, соёолоогүй, ялзраагүй, хатаж чийгээалдаагүй, ааг амт сайтай байна.<br>5. Сонгиныг стандартын шаардлага хангасан шуудай, торон уутандзэрэг, сортоор нь ялгаж савласан байна.<br>6 .Сонгиныг норох, хөлдөхөөс хамгаалсан тээврийн хэрэгслээртээвэрлэнэ.<br>7. Бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээгхангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ<br>8. Намрын улиралд шинэ ургацын сонгино нийлүүлэх. |
| | Лууван | 1.Нийлүүлэх лууван нь орон нутагт тариалагдсан , MNS 0271:1982стандартын шаардлага хангасан 1сорт байна.<br>2 Мэргэжлийн хяналтын лабораторит улирлаар шинжлүүлсэнхүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан,<br>3. Лууван нь нягт, шүүслэг, хөндийрөөгүй, модорч хөгшрөөгүй, үрчийгээгүй, соёолоогүй, гэмтээгүй, ялзраагүй,механик элдэв хольцгүй, гадны үнэр амтгүй байна.<br>4. Савлалт нь хуурай, цэвэр, даавуун шуудайд савласан байна.<br>5. Лууванг норох, хөлдөх, гэмтэхээс хамгаалжтээвэрлэнэ.<br>6. Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээгхангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.<br>7. Намрын улиралд шинэ ургацын лууван нийлүүлэх. |

| | | |
|---|---|---|
| | Шар, хүрэн манжин | 1. Нийлүүлэх манжин нь орон нутагт тариалагдсан , MNS 0268:1973стандартын шаардлага хангасан /1 дүгээр зэргийн<br>2. Мэргэжлийн хяналтын лабораторит улирлаар шинжлүүлсэнхүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан,<br>3. Ил болон хамгаалагдсан хөрсөнд ургуулсан манжинг нийлүүлнэ..<br>4. Хортон, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, үндэс үр нь шинэбүтэн,эрүүл, хагаралтгүй,<br>5. хөгшрөөгүй, наалдсан шороогүй, хуурай, сортынхоо хэлбэр,дүрсийг хадгалсан байна.<br>6. Савлалт нь хуурай, цэвэр, шуудайлж савласан байх.<br>7. Ногоог норох, хөлдөх гэмтэхээс хамгаалж тээвэрлэнэ. 7.Бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээгхангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ<br>8. Намрын улиралд шинэ ургацын манжинг нийлүүлэх. |
| **Багц-3 Сүү, Сүүн бүтээгдэхүүн** | Шингэн сүү<br>Тараг Аарц | 1. Сүү, сүүн бүтээгдэхүүн нь хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим MNS CAC 1:2003 стандартын шаардлага хангасан эрүүл ахуйн тохиромжтой нөхцөлд бэлтгэсэн байна.<br>2. Сүү нь түүхий сүүний техникийн шаардлага MNS 4228:2003 стандартыг хангасан байна.<br>3. Түүхий сүү нь малаас хүнд халдварлах өвчин болон малын гоц халдварт өвчнөөр өвчлөөгүй эрүүл бүсээс бэлтгэсэн байна.<br>4. Сүү, сүүн бүтээгдэхүүн нь Мэргэжлийн хяналтын лабораторитулирал тутам шинжлүүлсэн байх<br>5. Зориулалтын сав, баглаа, боодолтой байна.<br>6. .Хүнсний нэмэлт агуулаагүй байна.<br>7. Ариун цэврийн шаардлага хангасан тээврийн хэрэгслээртээвэрлэнэ.<br>8. Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцадтехнологийн горимыг чанд мөрдөнө.<br>9. Малын вакцин, тарилга туулгад хамрагдсан тухайд бүтээгдэхүүнийг нийлүүлэхгүй байх ба урьдчилан мэдэгдэнэ.<br>10. Бүтээгдэхүүний хэрэглэх заавар, зөвлөмж зэрэг нэмэлт мэдээллийг дагалдуулж болно.<br>12 Нийлүүлэгдэх тараг нь эсэг цагаан идээ техникийн шаардлага MNS 4230:2003 , бяслаг, аарц, ааруул нь уураглаг цагаан идээ техникийн шаардлага MNS 4230:2003стандартууд болон эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.<br>13. Үйлдвэрийн болон уламжлалт аргаар бэлтгэсэн, нэгэн жигд биебүтэцтэй, тослог зохих түвшинд байна.<br>14. Цагаан өнгөтэй, шинэлэг байдлаа хадгалсан, нэгэн жигд биебүтэцтэй, тослог зохих түвшинд байна.<br>Бүтээгдэхүүнийг ажлын өдөр хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийннийлүүлэлтийг хийнэ. |

| | | |
|---|---|---|
| **Багц-4** Мах махан бүтээгдэхүүн | Хонь, үхрийн мах | 1. **Үхэр, хонины 1дүгээр зэргийн**, өнгө, үнэр, биет байдал,гадаргуу, хэлбэр алдагдаагүй мах байна<br>2. Махыг хэсэглэж ангилсан байдлаар нийлүүлэх тохиолдолдMNS 2456:2009, MNS 2457:2009 стандартуудын шаардлагыг хангасан байна<br>3. Эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн шаардлага хангасан, эрүүлмалаас бэлтгэсэн байна.<br>4. Мал эмнэлэг, гарал үүслийн гэрчилгээ, хүнсний лабораторийншинжилгээний бичигтэй байна.<br>5. Загсаасан буюу сэрвээсэн эсвэл хөргөсөн, хөлдөөсөн мах байна.<br>6. Нөжирч хурсан цус, сэвс, үс, шороо зэрэг гадны бохирдолгүй,гадаргуу нь урагдаж гэмтээгүй байна.<br>7. Эрүүл ахуйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээртээвэрлэнэ.<br>8. Дулааны улиралд зориулалтын хөргүүрт хадгалах<br>9. Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийнгоримыг чанд мөрдөнө.<br>10. Бүтээгдэхүүнийг ажлын 7 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэгудаагийн нийлүүлэлтийг хийнэ. |
| **Багц-5** ***Кг-ын бүтээгдэхүүн, Жимс жимсгэнэ*** | 1,2-р гурил<br>Дээд гурил | 1. Хадгалалт сайн, Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, буудайн гурил байх, эрүүл ахуйн шаардлага хангасан шинжилгээний бичигтэй, илчлэг 328 ккал, чийглэг 15,5%, цавуулаг<br>26%-с багагүй. 324 ккал, чийглэг 22% |
| | Лапша гоймон 3 кг | 100 гр бүтээгдэхүүнд: Уураг 13,1гр,тослог 1,1гр, нүүрс ус 73гр,илчлэг 341 ккал, чийглэг 14%, хадгалалт сайн, стандартын шаардлага хангасан шинэ бүтээгдэхүүн байх |
| | Орос гоймон 5кг | 100 гр бүтээгдэхүүнд: Уураг 10,4гр,тослог 1,1гр, нүүрс ус 71,5гр,<br>чийглэг 14, хадгалалт сайн, стандартын шаардлага хангасан шинэбүтээгдэхүүн байх |
| | Шпагети гоймон | 100 гр бүтээгдэхүүнд: Уураг 11гр,тослог 1,1гр, нүүрс ус 74,5гр,<br>илчлэг 362 ккал, хадгалалт сайн,стандартын шаардлага хангасаншинэ бүтээгдэхүүн байх |
| | Цагаан будаа | MNS ISO 7301:2000 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөдхүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ<br>агуулагдсан байх, |
| | Шар будаа | MNS 0533:1998 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ<br>агуулагдсан байх |
| | Хөц будаа | MNS 4515:1997 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг<br>дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээагуулагдсан байх |

| | | |
|---|---|---|
| | Гурвалжин будаа | MNS 6511:2015 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүнийбие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимтбодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх |
| | Овьѐос хэмэгдэс | MNS ISO 6659-2003 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүнийбие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх |
| | Элсэн чихэр | MNS CAC 212:2014 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөдхүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээагуулагдсан байх |
| | Бүх төрлийн жигнэмэг | MNS 0158:1985 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх |
| | Ургамлын тос | MNS CAC 23-98 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх |
| | Оливын тос | MNS CAC 23-98 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүнийбие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх |
| | Хуурай цай | ‘’Гүржи ногоон’’ цайтай дүйцэхүйц сайн чанарын ,эрүүл ахуй,ариун цэврийн стандарт шаардлагад нийцсэн |
| | Давс | Эх орны үйлдвэрийн давстай дүйцэхүйц, эрүүл ахуйн стандартшаардлагад нийцсэн, сайн чанарын иоджуулсан давс |
| | Исгэгч | Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийнстандарт шаардлагаднийцсэн бүтээгдэхүүн байна |
| | Сод | Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийнстандарт шаардлагаднийцсэн бүтээгдэхүүн байна |
| | Вандуй ,эрдэнэ шиш | Сайн чанарын эрүүл ахуй, ариун цэврийнстандарт шаардлагаднийцсэн бүтээгдэхүүн байна. |
| | Үзэм | Гадаад байдал нь элдэв толбо үүсээгүй, тухайн жимсний сортондтохирсон өнгө үзэмж хэлбэр хэмжээтэй гадны элдэв амт үнэргүй хорчийж хатаагүй,хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг бүрэн хангасан, |

| | | |
|---|---|---|
| | Далайн байцай | Солонгос улсад үйлдвэрлэгдсэнбүтээгдэхүүнтэй дүйцэхүйц, Сайнчанарын,эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн |
| | Бусад нэр төрөл / Жимс:Алим/Белги,Польш улс/жонны сорт/гэх мэт,Жүрж,Ванан/орос/,помидор, Мандарин гэх мэт | Хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх, дагалдах шинжилгээний бичгүүдийг нийлүүлэлт тухайбүрд тогтмол өгч байх шаардлагатай. |
| | Өндөг | MNS 0095 : 1977 стандарт хангасан байх шаардлагатай |
| **Багц-6** ***Жимсний шүүс*** | Нэрсний шүүс | MNS CAC103-1999 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөдхүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ<br>агуулагдсан байх, зориулалтын саванд савлаж, дараахмэдээлэлийгагуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:<br>• Үйлдвэрлэгчийн нэр<br>• Бүтээгдэхүүний нэр, төрөл<br>• Цэвэр жин<br>• Үйлдвэрлэсэн огноо,<br>• Стандартын дугаар<br>• Хэрэглэх аргын заавар<br>Шошголохтой холбогдсон журам MNS6648:20162-ын шаардлагахангасан |
| | Аньсний шүүс | MNS 1977-1986 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүнийбие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх, зориулалтын саванд савлаж, дараахмэдээлэлийгагуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:<br>• Үйлдвэрлэгчийн нэр<br>• Бүтээгдэхүүний нэр, төрөл<br>• Цэвэр жин<br>• Үйлдвэрлэсэн огноо,<br>• Стандартын дугаар<br>• Хэрэглэх аргын заавар<br>Шошголохтой холбогдсон журам MNS6648:20162-ын шаардлагахангасан |

| | | |
|---|---|---|
| | Чацаргана жимсээрээ | MNS0916-2011стандарт хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх, зориулалтын саванд савлаж, дараахмэдээлэлийгагуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:<br>• Үйлдвэрлэгчийн нэр<br>• Бүтээгдэхүүний нэр, төрөл<br>• Цэвэр жин<br>• Үйлдвэрлэсэн огноо,<br>• Стандартын дугаар<br>• Хэрэглэх аргын заавар<br>Шошголохтой холбогдсон журам MNS6648:20162-ын шаардлагахангасан |
| | Үхрийн нүдний шүүс | MNS CAC103-1999 стандарт хангасан байх шаардлагатай бөгөөдхүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ<br>агуулагдсан байх, зориулалтын саванд савлаж, дараахмэдээлэлийгагуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:<br>• Үйлдвэрлэгчийн нэр<br>• Бүтээгдэхүүний нэр, төрөл<br>• Цэвэр жин<br>• Үйлдвэрлэсэн огноо,<br>• Стандартын дугаар<br>• Хэрэглэх аргын заавар<br>Шошголохтой холбогдсон журам MNS6648:20162-ын шаардлагахангасан |

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

**БАГЦ 1: Гурилан бүтээгдэхүүн**

*[Захиалагч энэхүү хүснэгтийн1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]*

| **Нэр** | **Барааны тодорхойлолт** | **Тоо ширхэг** | **Хэмжих нэгж** | **ТШӨХ-д заасан бараагхүргэх эцсийн цэг (Ажлын талбай)** | **бараа нийлүүлэх хугацаа** | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа** | **Бараа нийлүүлэх эцсийн хугацаа** | **Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа *(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)*** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Талх амтлаг | Захиалгын тоогоор | ш | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 2 | Талх хөх тариа | Захиалгын тоогоор | ш | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 3 | Боов төрөл бүрийн,жигнэмэг/ 0,45-0,9кг/ | Захиалгын тоогоор | уут | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |

**БАГЦ 2: Хүнсний ногоо / ::::::::::::::::::::**

*[Захиалагч энэхүү хүснэгтийн1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]*

| Нэр | Барааны тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай) | бараа нийлүүлэх хугацаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Бараа нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа *(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)* |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Төмс | Захиалгын тоогоор | кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 2 | Сонгино | Захиалгын тоогоор | кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 3 | Байцаа | Захиалгын тоогоор | кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 4 | Өргөст хэмх | Захиалгын тоогоор | кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 5 | Лууван | Захиалгын тоогоор | кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 6 | Чинжүү | Захиалгын тоогоор | кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Манжин шар | Захиалгын тоогоор | кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 8 | Сармис | Захиалгын тоогоор | кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 9 | Улаан лооль | Захиалгын тоогоор | кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |

**БАГЦ 3: Сүү сүүн бүтээгдэхүүн/....................**

*Захиалагч энэхүү хүснэгтийн1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]*

| **Нэр** | **Барааны тодорхойлолт** | **Тоо ширхэг** | **Хэмжих нэгж** | **ТШӨХ-д заасан бараагхүргэх эцсийн цэг (Ажлын талбай)** | **бараа нийлүүлэх хугацаа** | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа** | **Бараа нийлүүлэх эцсийн хугацаа** | **Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа *(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)*** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Сүү | Захиалгын тоогоор | л | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 2 | Аарц | Захиалгын тоогоор | кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| *3* | Тараг | Захиалгын тоогоор | л | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| *4* | *Өрөм* | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| *5* | *Цөцгий* | Захиалгын тоогоор | л | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |

**БАГЦ 4: Мах / ...**

*[Захиалагч энэхүү хүснэгтийн1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]*

| Нэр | Барааны тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан бараагхүргэх эцсийн цэг (Ажлын талбай) | бараа нийлүүлэх хугацаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа** | **Бараа нийлүүлэх эцсийн хугацаа** | **Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа *(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)*** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Үхрийн мах | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 2 | Хонины мах | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |

**БАГЦ 5: Килограммын бүтээгдэхүүн , жимс жимсгэнэ**

*[Захиалагч энэхүү хүснэгтийн1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]*

| **Нэр** | **Барааны тодорхойлолт** | **Тоо ширхэг** | **Хэмжих нэгж** | **ТШӨХ-д заасан бараагхүргэх эцсийн цэг (Ажлын талбай)** | **бараа нийлүүлэх хугацаа** | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа** | **Бараа нийлүүлэх эцсийн хугацаа** | **Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа *(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө*)** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Хүүхдийн будаа | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 2 | гоймон | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 3 | Давс | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 4 | Гурил 1,2-р ;дээд | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 5 | Гурил бүхэл үр | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 6 | Ногоон цай | Захиалгын тоогоор | Ш | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 7 | Үзэм орос | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 8 | Хөц будаа | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Цагаан будаа | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 10 | Шар будаа | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 11 | Гурвалж ин будаа | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 12 | Гоймон шпагета | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 13 | Гоймон хэлбэртэй | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 14 | Элсэн чихэр | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 15 | Масло 82% | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын31 | |
| 16 | Ургамлын тос /олейна/ | Захиалгын тоогоор | л | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 Сарын 31 | |
| 17 | Исгэгч /орос/ | Захиалгын тоогоор | ш | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 18 | Вандуй | Захиалгын тоогоор | ш | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 19 | Молоко | Захиалгын тоогоор | Л | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 20 | Варень | Захиалгын тоогоор | Ш | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | Далайн байцаа солонгос | Захиалгын тоогоор | Ш | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 22 | Овьѐосны хэмхтэс | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 23 | Цайны печень | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 24 | Жигнэмэг | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 25 | Оливын тос | Захиалгын тоогоор | Л | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 26 | Өндөг | Захиалгын тоогоор | Ш | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 27 | Жүрж,Алим ,Банан гэх мэт | Захиалгын тоогоор | Кг | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |

**БАГЦ 6: жимсний шүүс**

*[Захиалагч энэхүү хүснэгтийн1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө]*

| **Нэр** | **Барааны тодорхойлолт** | **Тоо ширхэг** | **Хэмжих нэгж** | **ТШӨХ-д заасан бараагхүргэх эцсийн цэг (Ажлын талбай)** | **бараа нийлүүлэх хугацаа** | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа** | **Бараа нийлүүлэх эцсийн хугацаа** | **Нийлүүлэгчийнсанал болгосон хугацаа *(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)*** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Үхрийн нүдний шүүс | Захиалгын тоогоор | Л | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 2 | Нэрсний шүүс | Захиалгын тоогоор | Л | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| 3 | Аньсны шүүс | Захиалгын тоогоор | Л | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |
| *4* | Чацаргана жимсээрээ | Захиалгын тоогоор | *кг* | ЕБ-н 4-р сургууль хүнсний агуулах | Гэрээ байгуулсан өдрөөс | 2024 оны 12 сарын 31 | |

# IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУРҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.*

*Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 32.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.*

*Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.*

1. *Бараа нийлүүлэлтийн хуваарь:* ***Ашиглана***
   *Хэрэв "ашиглах" бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (барааны нийлүүлэлт хийх хамгийн эхний өдрөөс хойш нийлүүлэлт хийвэл зохих хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) нийлүүлэгдсэн байх шаардлагатай. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас өмнө нийлүүлэх санал ирүүлсэн тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.*

   *Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд* ***[хувь бич]****–иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.*

   *Барааг хуваарьт зааснаас* ***1 хонгоос илүү болон барааг "нийлүүлтийн хуваарь"- т хугацааны дагуу ирүүлээгүй болон хоцроож хүргэхийг санал болгосон тендерээс татгалзана.*** *Харин ТӨХ-д тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон бараа нийлүүлэлтийн хуваариас урагш болон хойш нийлүүлэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.*

2. *Тендерт санал болгосон барааны урсгал зардал, үйл ажиллагааны баталгаа болонүр ашигтай байдал:* ***"Ашиглахгүй"***
3. *Тендерт санал болгосон барааны борлуулалтын дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: "****Ашиглахгүй"***
4. *Тендерийн дагуу санал болгож байгаа барааны гол эд анги, зайлшгүй шаардлагатайсэлбэг хэрэгсэл болон үйлчилгээний зардал:* ***"Ашиглахгүй"***

# V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД


Маягт 1 Тендер илгээх маягт ........ 2

Маягт 2 Барааны үнийн задаргаа ........ 3

Маягт 3 Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл ........ 4

Маягт 4 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл ........ 5

Маягт 1 Тендер илгээх маягт

[огноо]

Увс аймгийн Улаангом сумын ЕБ-ын 4-р сургууль

Манай ***[тендерт оролцогчийн нэр]*** нь танай байгууллагаас зарласан ***[тендер шалгаруулалтын нэр, дугаар]*** тендер шалгаруулалтад ***[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталжэнэхүү тендер (цаашид “**тендер**” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээний маягт)-ын нөхцөлтэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 15.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш ***[30 ба түүнээс дээш хоногийн тоо]*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 12.4 болон 15.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:Хаяг:

Маягт 2 Барааны үнийн задаргаа

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **№** | **Барааны нэр** | **Гарал үүслийн улс**[1] | **Тоо хэмжээ** | **Хэмжих нэгж, тун** | **Нэгж үнэ** | **Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)** | **Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ** | **Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж** | **Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)** | **Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх**[2] |
| 1 | | | | | | | | | | *Тийм/Үгүй* |
| 2 | | | | | | | | | | |
| .. | | | | | | | | | | |
| | **Тендерийн нийт үнэ** | | | | | | | | | |

[1] ТШЗ-ны 16.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

[2] Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт "тийм" гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

Маягт 3 Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

| **Гэрээний нэр** | **Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас** | **Төсөвт өртөг** | **Хугацаа /эхэлсэн, дууссан/** |
| --- | --- | --- | --- |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Маягт 4 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

| |
|---|
| Тендерт оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсонгэрээ тус бүрээр бөглөнө]*. |

| | |
|---|---|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br>□Үндсэн нийлүүлэгч □Түншлэлийн гишүүн □Туслан гүйцэтгэгч |
| 8. | Хавсралт<br>- Гэрээний хуулбар<br>- Гэрээ дүгнэсэн акт / бараа хүлээлцсэн акт / захиалагчийн тодорхойлолт |

# VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид "ГЕН" гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид "ГТН" гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоѐр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийггэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

**ГЭРЭЭНИЙ**
**НӨХЦӨЛГАРЧИГ**


ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ ........ 3
НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР ........ 3
Тодорхойлолт ........ 3
Тайлбар ........ 4
ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ ........ 4
Бараа нийлүүлэх ........ 4
Бараа нийлүүлэх газар ........ 5
Барааг хүлээлгэн өгөх ........ 5
Барааны гарал үүслийн улс ........ 5
Баглаа боодол ........ 5
Худалдааны нөхцөл ........ 5
ГУРАВ. ЗАХИАЛАГЧ ........ 5
Барааг хүлээн авах ........ 5
Шалгалт, туршилт ........ 5
Гэрээний үнэ ........ 6
Төлбөр төлөх ........ 6
ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА ........ 6
Захиалагчийн хүлээх эрсдэл ........ 6
Даатгал ........ 6
Доголдол ........ 6
Чанарын баталгаа ........ 7
Алданги ........ 7
Оюуны өмчийн эрх зөрчих ........ 8
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал ........ 8
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа ........ 8
ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ ........ 8
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл ........ 8
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл ........ 9
ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ ........ 9
Төлөөлөгч ........ 9
Нууцлал ........ 9
Мэдэгдэл ........ 9
Маргаан шийдвэрлэх ........ 10
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ ........ 11
ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ ........ 12

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

**Тодорхойлолт**

1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:

1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;

1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;

1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нь нэрлэснийг;

1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;

1.1.8. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;

1.1.9. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;

1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.11. “Хоног” гэж хуанлийн хоногийг;

1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар

Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийнгамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй /, гоцхалдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

**Тайлбар**

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно;

1.2.2. бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй;

1.2.3. зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана;

1.2.4. ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална;

1.2.5. гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

**Бараа нийлүүлэх**

2.1. Нийлүүлэгч нь Гэрээ болон Бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдахүйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

2.2. Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад тэдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

2.3. ГЕН-ийн 1.4-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.

2.4. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

**Бараа нийлүүлэх газар**

2.5. Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.

**Барааг хүлээлгэн өгөх**

2.6. Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, тэмдэглэл үйлдэнэ.

2.7. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөхэрх шилжинэ.

**Барааны гарал үүслийн улс**

1.8. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасанулсын гарал үүсэлтэй байна.

2.9. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.

**Баглаа боодол**

2.10. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.

2.11. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд холбогдох хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.

2.12. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.

**Худалдааны нөхцөл**

2.13. Гэрээнд хэрэглэж байгаа Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг ГТН-д заана.

2.14. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр ГЕН-ийн 2.5-д заасан газарт хүргүүлэхнэ.

## ГУРАВ. ЗАХИАЛАГЧ

**Барааг хүлээн авах**

1.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

**Шалгалт, туршилт**

3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.

3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийгхязгаарлахгүй.

3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.

**Гэрээний үнэ**

3.7. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

3.8. Гэрээний үнэд тохируулга хийхгүй.

**Төлбөр төлөх**

3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.

3.10. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ѐсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

3.11. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.12. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

3.13. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардахэрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

## ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

**Захиалагчийн хүлээх эрсдэл**

4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна.

4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;

4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН- ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.

**Даатгал**

4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж даатгалынгэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.

**Доголдол**

4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчидмэдэгдэнэ.

4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.

4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.

4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.

4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.

4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.

**Чанарын баталгаа**

4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацаагГТН-д заана.

4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.

4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаа гарган баталгаажуулж болно.

4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаа гаргасан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагцүлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.

4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

**Алданги**

4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.

4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид

төлнө.

**Оюуны өмчийн эрх зөрчих**

4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.

**Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал**

4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН- ийн 6.8-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.

4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыгхайна.

4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Захиалагч Бараа нийлүүлэх хугацаагсунгаж болно.

**Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа**

4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ.Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.

4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.8-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

## ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

**Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл**

5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:

5.1.1. нийлүүлэгч үүргээ гэрээнд заасан хугацаанд, эсхүл зохих ѐсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч Нийлүүлэгч нэмэлтхугацаанд үүрэг гүйцэтгээгүй;

5.1.2. бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;

5.1.3. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авилгал, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.

5.2. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.

5.3. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.

**Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл**

5.4. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

## ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

**Төлөөлөгч**

6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажлын болон өөрийн гар утасны дугаар, цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.

6.3. Гэрээг хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

**Нууцлал**

6.5. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтанд авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.

6.6. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.

**Мэдэгдэл**

4.7. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

4.8. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.7 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

4.9. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх, эсхүл шуудангаарнөгөө талын гэрээ Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

4.10. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

4.10.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

4.10.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор тэмдэглэлийг үндэслэн;

4.11. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийнхаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

4.12. ГЕН-ийн 6.3-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэхүр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

**Маргаан шийдвэрлэх**

4.13. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

4.14. Талууд зөвшилцөн шийдвэрлэж эс чадвал Монгол улсын хууль тогтоомжийн дагуу гэрээний үүргийн гүйцэтгэл болон гэрээг цуцалсан, гэрээнээс татгалзсантай холбоотой аливаа маргааныг Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ.

# ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| ГЕН 2.1. | **Бараа нийлүүлэх хугацаа:**<br>*Бараа нийлүүлэх хугацаа:* ***[2024-02-12 - 2024-12-31]*** |
| ГЕН 2.5. | **Бараа нийлүүлэх газар:**<br>***Увс аймаг ЕБ-ын 4-р сургууль*** |
| ГЕН 2.6. | **Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:**<br>***Увс аймгийн ЕБ-ын 6-р сургууль хүнсний агуулахад өөрийнунаагаар хүргэж хүлээлгэн өгнө.*** |
| ГЕН 2.10. | **Баглаа, боодол:**<br>***Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна .*** |
| ГЕН 2.13. | **Худалдааны нөхцөл:**<br>**Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг.Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms2020DeIivety Duty Paid/DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.**<br>***[Тендерийн баримт бичгийн ТӨХ-д заасан бол ТШЗ 18.6-д заасанХудалдааны нөхцөл (Incoterms)*** |
| ГЕН 3.9. | **Төлбөр төлөх хугацаа:**<br>Төлбөр төлөх хугацаа : Сар бүрийн 25-нд тооцоо нийлж баталгаажуулан ажлын 3 өдөрт багтаан гүйлгээ хийгдэнэ. / Санхүүжилт хийгдсэн огнооноос хамаарч өөрчлөгдөж болно. / |
| ГЕН 4.17. | **Нийлүүлэгчийн төлөх алданги:**<br>Алдангийн хувь: ***[хоногт 0.5 хүртэл хувиар ]*** |
| ГЕН 4.18. | **Захиалагчийн төлөх алданги:**<br>Алдангийн хувь: ***[хоногт 0.5 хүртэл хувиар ]*** |

**ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ**

[Тендер шалгаруулалтын нэр] гэрээ

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаар]

.............................. хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ......... оны .......... сарын.. -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Захиалагч нь ***[гэрээний нэр, дугаар]***-г (цаашид “бараа” гэх) ***[гэрээний үнийг тоогоор болон үсгээр бичих]*** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг нийлүүлэгч ............-ийн харилцах ............банкны дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
    1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
    2. Гэрээ баталгаажуулах маягт;
    3. Гэрээний тусгай нөхцөл;
    4. Гэрээний ерөнхий нөхцөл;
    5. Техникийн тодорхойлолт;
    6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхийэтгээдүүд төлөөлнө. Үүнд:

5.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх/ -ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

5.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэлЭцэг/эх/-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]________________

ТАМГА

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _______________

ТАМГА

# VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

**Санамж**

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид "ГЕН" гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид "ГТН" гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:

1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;

1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;

1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;

1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.

1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;

1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;

1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;

1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал“ гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх

2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.

2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд

Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

**Бараа нийлүүлэх газар**

2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.

**Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах**

2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.

2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.

2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.

**Барааг хүлээлгэн өгөх**

2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.

**Барааны гарал үүслийн улс**

2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.

2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.

**Баглаа боодол**

2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.

2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.

2.16 Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.

**Худалдааны нөхцөл**

2.17 Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.

2.18 ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.

Гүйцэтгэлийн баталгаа

2.19 Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.

2.20 Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:

2.20.1 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;

2.20.2 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.20.3 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.

2.21 Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.

2.22 ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.

2.23 Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.

## ГУРАВ. ЗАХИАЛАГЧ

Барааг хүлээн авах

3.1 Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

Шалгалт, туршилт

3.2 Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.

3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.

Гэрээний үнэ

3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.

Төлбөр төлөх

3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.

3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

## ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

Захиалагчийн хүлээх эрсдэл

4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:

4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;

4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.

Даатгал

4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.

Доголдол

4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.

4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.

4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.

4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.

4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.

4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.

**Чанарын баталгаа**

4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.

4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.

4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.

4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.

4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

**Алданги**

4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.

4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.

**Оюуны өмчийн эрх зөрчих**

4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.

**Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал**

4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр

урьдчилан мэдэгдэж болно.

4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.

4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.

Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа

4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.

4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

## ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл

5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:

5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;

5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;

5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.

5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.

5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.

5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.

5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл

5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

## ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

Төлөөлөгч

6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.

6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Туслан гүйцэтгэгч

6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.

Нууцлал

6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.

6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.

Мэдэгдэл

6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шуудfestival хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

| | | |
|---|---|---|
| | 6.13. | Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ. |
| | 6.14. | ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна. |
| Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах | 6.15. | Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:<br>6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;<br>6.15.2. үнийн тохируулга хийсэн. |
| | 6.16. | Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно. |
| | 6.17. | ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй. |
| Маргаан шийдвэрлэх | 6.18. | Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. |
| | 6.19. | Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ. |

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| **ГЕН 2.5.** | Бараа нийлүүлэх газар**:**<br>***[Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх газрын хаяг, байршил гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй бичих]*** |
| **ГЕН 2.6.** | Бараа нийлүүлэх хугацаа:***[огноо бичих]***<br>*Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа:****[огноо бичих эсхүл нийлүүлэлтийн хуваарь байгаа бол түүнийг ишлэх]*** |
| **ГЕН 2.10.** | Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:<br>***[Бараа хүлээлгэн өгөх нөхцөлийг тодорхой бичих]***<br>Бараанд холбогдох баримт бичиг: ***[бараанд холбогдох ямар баримт бичгүүдийг хүлээлгэж өгөх талаар бичих]***<br>Угсралт, суурилуулах: ***[ямар барааг юунд, хэрхэн угсарч,суурилуулах гэх мэт.]*** |
| **ГЕН 2.14.** | Баглаа, боодол:<br>***[Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөл, шаардлагыг тодорхой бичих.]***<br>***[Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг бичих]***<br>*Баглаа, боодлын шаардлага:*<br>***Жишээ нь:***<br>***[Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих,*** |

| | |
|---|---|
| | ***буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна гэх мэт]*** |
| **ГЕН 2.17.** | Худалдааны нөхцөл:<br><br>***[Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 20.6-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хуулж бичих]*** |
| **ГЕН 3.8.** | Үнийн тохируулга хийх аргачлал:<br><br>***"Ажиллах хүч болон материалын үнийн өөрчлөлтийг тусгах зорилгоор гэрээний хэрэгжилтийн явцад нийлүүлэгчид төлөх үнийг дараах томьёог ашиглан тохируулна:***<br><br>$$DP = P_0 \left( a + b \frac{L_1}{L_0} + c \frac{M_1}{M_0} \right) - P_0$$<br><br>***Үүнд:***<br><br>***DP -нийлүүлэгчид төлөх нэмэгдэл үнэ***<br><br>***$P_0$-гэрээний үндсэн үнэ;***<br><br>***a -гэрээний үнэд шингэсэн ашиг, захиргааны зардлын тогтмол дүн. Ихэнх тохиолдолд 5-15 хувийн хооронд хэлбэлздэг;***<br><br>***b -гэрээний үнэд ажиллах хүчний эзлэх хувь;***<br><br>***c -гэрээний үнэд материалын эзлэх хувь;***<br><br>***$L_0$-гарал үүслийн улсын холбогдох салбарын ажиллах хүчний өдрийн индекс;***<br><br>***$L_0$, $L_1$ -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй холбогдох салбарын ажиллах хүчний суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс;***<br><br>***$M_1$ $M_0$ -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй үндсэн барааны суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс.***<br><br>***[захиалагч a, b, c илтгэлцүүрүүдийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана. Энэ гурван итгэлцүүрийн нийлбэр дүн аль ч тохиолдолд нэг (1) байна.]***<br><br>***Тендерт оролцогч индексийн эх үүсвэр болон суурь өдрийн индексийг өөрийн тендерт зааж өгнө.***<br><br>***Суурь өдөр нь тендер зарласан өдөр байна.***<br><br>***Үнэ тохируулах өдөр нь барааг тээвэрлэхээс [тоо бичих][1] долоо хоногийн өмнөх өдөр байна (үүнийг үйлдвэрлэх явцын дунд үе гэж ойлгоно).***<br><br>***Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд үнийг тохируулах санал гаргах эрхтэй. Үүнд:***<br><br>***1. Гэрээний суурь үнэ [тоо бичих][2] хувиас илүү өсөх, эсхүл буурахаар бол үнийг тохируулна.***<br><br>***2. Гэрээг сунгах албан бичигт онцгойлон өөрөөр заагаагүй бол барааг нийлүүлэх анхны хуваариас хоцорч нийлүүлсэн хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Нийлүүлэгчээс шалтгаалан хоцорсон хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Гэхдээ гэрээний үнэ буурах үнийн тохируулгыг захиалагч эдгээр хугацаанд хийж болно.***<br><br>Гэрээний үнийн /P0/ валют, ажиллах хүч болон материалын индекс нь гарал |

[1]Захиалагч шаардлагатай долоо хоногийн тоог заана.
[2]Арван таван (15) хувийг зүйтэй хэмжээ гэж үзнэ.

| | |
|---|---|
| | үүслийн улсын валютаас өөр байх тохиолдолд, гэрээний үнийн тохируулалт буруу хийгдэхээс урьдчилан сэргийлж, залруулах итгэлцүүрийг ашиглана. Залруулах итгэлцүүр нь тус хоёр валютын суурь өдөр болон үнэ тохируулах өдрийн ханшны харьцаа байна. |
| **ГЕН 3.9.** | Төлбөр төлөх хугацаа: *[он, сар, өдөр]*<br><br>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд төлбөр төлөх үе шатны хугацаа: ***[он, сар, өдөр]*** |
| **ГЕН 4.2.** | Даатгал:<br><br>***[Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрөл заах]*** |
| **ГЕН 4.10.** | Баталгаат хугацаа:<br><br>***[Баталгаат хугацаа заасан эсэх, заасан бол тендер шалгаруулалтын баримт бичигт үндэслэн хугацааг тогтоож бичих]*** |
| **ГЕН 4.11** | Чанарын баталгаа:<br><br>Чанарын баталгаа шаардах эсэх: ***[Чанарын баталгаа шаардана/ шаардахгүй]***<br><br>***Чанарын баталгаа шаардах бол,***<br>Чанарын баталгааны дүн:***[Гэрээний үнийн дүнгийн 5-10 хувь байхаар бичих]*** |
| **ГЕН 4.17.** | Нийлүүлэгчийн төлөх а**лданги:**<br><br>Алданги тооцох эсэх**: *[“Тийм”, “Үгүй” гэдгээс сонгох]***<br>Алдангийн хувь**: *[хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]*** |
| **ГЕН 4.18.** | Захиалагчийн төлөх а**лданги:**<br><br>Алданги тооцох эсэх**: [“Тийм”, “Үгүй” гэдгээс сонгох]**<br>Алдангийн хувь: ***[хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]*** |

# ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

***[Тендер шалгаруулалтын нэрийг бичих]*** гэрээ.
Дугаар № ***[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]***

.............................. хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэрийг бичих]*** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь ***[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]*** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Нийлүүлэгч ***[Нийлүүлэгчийн нэрийг бичих]***-ийн харилцах ***[Банкны нэрийг бичих]*** банкны ***[дансны дугаар бичих]*** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
    - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
    - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
    - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
    - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
    - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
    - 3.6. Техникийн тодорхойлолт;
    - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
    - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
      Эцэг/эх-ийн нэр:
      Нэр:
      Албан тушаал:
      Ажлын утас:
      Гар утас:
      Цахим шуудан:

    - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
      Эцэг/эх-ийн нэр:
      Нэр:
      Албан тушаал:
      Ажлын утас:
      Гар утас:
      Цахим шуудан:

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| [Албан тушаал, нэр] | [Албан тушаал, нэр] |
| [Гарын үсэг]______________ | [Гарын үсэг] _____________ |

# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо[3] : ***2024.01.15***

Тендер шалгаруулалтын нэр: *Үдийн хоол хөтөлбөрт бүтээгдэхүүн нийлүүлэх*

Тендер шалгаруулалтын дугаар: УВААС4/202400101

***Увс аймгийн ЕБ-ын 4-р сургууль*** нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг

***1-5 р ангийн сурагчдын Үдийн хоол хөтөлбөрийн хүнснийбүтээгдэхүүн нийлүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.***

**1 –р áàãö: Гурилан бүтээгдэхүүн**

**2 –р багц: Хүнсний ногоо**

**3- р багц: Сүү, сүүн бүтээгдэхүүн**

**4-р багц: Мах /үхэр, хонь /**

**5-р багц: Хүнсний КГ-ын бүтээгдэхүүн,жимс жимсгэнэ**

**6 –р багц:Жимсний шүүс/үхрийн нүд, чацаргана жимсээрээ аньс/**

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50000 төгрөгийг цахим систем ашиглан төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Гадаадын этгээд тендер ирүүлэх:Эрхгүй

Дотоодын давуу эрх тооцох эсэх:Тооцно

Тендерийг ***2024-02-09-ны өдрийн 13:00 цагаас /орон нутгийн цагаар 13:00/*** өмнө www.tender.gov.mn хаягаар тендерийн баримт бичигт заасан журмаар ирүүлэх ба тендерийн нээлтийг ***2024-02-09-****ны өдрийн****, 13:30*** *цагт / орон нутгийн цагаар 12:30цаг /* зохион байгуулна.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэлавах хүсвэл доорх утсаар авч болно.

Увс аймгийн Улаангом сум Ерөнхий боловсролын 4-р сургууль
Утас: 99961861 95731517